

## ХҮРД ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХИ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд талархаж, хурлын ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч оролцохыг хүсч байна.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ-ийн хурлыг тогтмол хийж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, компанийн үйл ажиллагаа, ажиллагсдын цалин хөлс урамшуулал, хөрөнгийн өсөлт бууралт, ногдол ашиг, удирдлагын урамшуулал олгох асуудлыг хэлэлцэж баталж ирсэн байна.

Компанийн ТУЗ 11 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг болон удирдлагын урамшуулал олгох, компанийн хэтийн хөгжил, засаглалыг сайжруулахад зориулж шинэ залуу боловсон хүчин бэлтгэхэд сургалтын төлбөрийн асуудлыг шийдэх, бизнес төлөвлөгөөний биелэлт, компанийн үйл ажиллагаа, барилга угсралтын ажлын явцтай танилцах, барилга угсралтын ажлын санхүүжилтын векселийг худалдах зөвшөөрөл олгох, түрээсийн төлбөрийг шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.

2013 онд компанийн нэгж хувьцаанд **253** төгрөг, нийт **34.2** сая төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2014 онд нэгж хувьцаанд **273** төгрөг, нийт **36.9** сая төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2013 оны ажлын үр дүнд **"хангалттай"** гэсэн дүгнэлт өгсөн болон , удирдлагын урамшуулал олгох журмыг үндэслэж, ТУЗ болон удирдлагын урамшилд **20,2** сая төгрөг олгосон.

2014 онд компанийн удирдлагын зардлыг **210.0** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь **203,4** сая төгрөг болж **6,6** сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

Тайлант онд компанийн засаглалын сургалтад ТУЗ-ийн гишүүн, нарийн бичиг 10 хүнээс 7 хүн хамрагдаж, компанийн ТУЗ засаглалын чадамжтай ТУЗ боллоо. Үлдэх 3 гишүүн сургалтад хамрагдах шаардлагатайг анхаарах. Энэ сургалтад 2.5 сая төгрөг зарцуулсан байна.

2014 онд 2 инженер сургалтад хамрагдаж мэргэшсэн инженер зэрэг авч, компанийн чухал хэрэгцээт мэргэжлээр 6 удаагийн сургалтад 14 хүн хамрагдаж шинээр буюу дагалдах мэргэжил эзэмшсэн байна. Эдгээр сургалтад 4.2 сая төгрөг зарцууллаа.

Мөн компанийн ирээдүйн боловсон хүчин бэлтгэхэд 150.0 сая төгрөг компанийн ТУЗ-өөр шийдвэрлэж олгосон байна. Энэ зардлыг бүх гишүүдийн хурлаар баталгаажуулах санал оруулж байна.

Компани санхүүгийн хувьд мөнгөн хөрөнгө, материалын зохих нөөцийг бүрдүүлж, эдийн засгийн хүч чадал өсөн нэмэгдэж байна.

Компанийн үл хөдлөх хөрөнгө **216,16** сая төгрөгийн өртөг бүхий 9 барилга байгууламж байгаа нь 2014 онд өөрчлөлт ороогүй байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 1 тэрбум 43,5 сая төгрөг байсан бөгөөд доорх өөрчөлт орсон байна. Үүнд: 44 нэр төрлийн 6,34 сая төгрөгийн өртөг бүхий аж

төрлийн 2,13 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, бүгд 8,87 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдаж, машин механизмын хэсэгт 50,0 сая төгрөгийн экскаватор, 1,61 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, бүгд 51,61 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 1 тэрбум 87, 2 сая төгрөг болж, 43,7 сая төгрөгөөр өсчээ.

Ашиглалтаас хассан цехүүдийн 2,13 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг 10,06 сая төгрөгөөр зарж борлууллаа.

Мөн Мөнх-Тооройт ХХК-д барилга угсралтын ажлын санхүүжилтэд тооцон 1995 оны 47,7 сая төгрөгийн үнэтэй, одоо 33,5 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй экскаваторыг засварлаж, 50,0 сая төгрөгөөр /зах зээлийн үнээр/ шилжүүлсэн болно.

Компанийн мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад анхаарч, харилцагч банкуудаас харилцахын үлдэгдэлд олгох хүүгийн хувь хэмжээний талаар санал авч, судалгаа хийсний үндсэн дээр өндөр хүү олгож байгаа Төрийн банкинд мөнгөн хөрөнгийн ихэнх хэсгийг байршуулж, оны эхэнд харилцахын үлдэгдэлд сар бүр 0,4% -аар хүү олгож байсныг дахин дахин хүсэлт тавьж харилцахын хүүг 0,6%, 0,8% болгон үе шаттайгаар ахиулснаар 2014 онд байгууллагын харилцахын үлдэгдэлд 252,2 сая төгрөгийн хүүгийн орлого, мөн найдвартай компаниудад богино хугацаатай зээл олгож, 9,0 сая төгрөгийн орлого авсан байна.

Компани 2014 онд **7 тэрбум 6 сая** төгрөгний БУА, материал нийлүүлэлтийн ажил гүйцэтгэж, **284.86** сая төгрөгийн материал, бэлэн бүтээгдэхүүн гадагш борлуулжээ.

БУА, материал үйлдвэрлэл, худалдааны үйлчилгээ эрхэлж **7 тэрбум 291** сая.төгрөгийн борлуулалт хийж **409.4** сая.төгрөгийн ашигтай ажилласнаас компанийн цэвэр ашиг **368.5** сая.төг байна. Компанийн хэмжээнд 1 төгрөгний БУА-ын өөрийн өртөг **92.2** мөнгө байна.

Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн, газрын, тээврийн хэрэгслийн татварт **425.8** сая төгрөг, мөн нийгмийн даатгалын шимтгэлд **111.3** сая төгрөг төлж, улсын татварын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

Азийн хөгжлийн банк болон улс, хот, орон нутгийн хөрөнгөөр санхүүжих **16** сонгон шалгаруулалтад оролцсоноос **3** тендерт шалгарч, **3'012.6** сая. төгрөгийн өртөг бүхий ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан болно.

Компани 2014 онд урьд онуудаас шилжсэн 18 барилга, шинээр ажил эхлүүлсэн 3 барилгад барилга угсралтын ажил гүйцэтгэлээ.

Компани гэрээт олон ажлуудыг цаг хугацаанд нь амжилттай хэрэгжүүлж ажиллаж ирлээ.

Бид өнгөрсөн онд Азийн хөгжлийн банкны зээлээр санхүүжсэн Говь-Алтай аймгийн Алтай хотын усан хангамж, ариутгах татуургын системийг сайжруулах ажил, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн Зүүнбаян сумын халаалтын зуух шинэчлэлтийн ажил, Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах Багц-8 ажил, Налайх дүүргийн Дулааны цахилгаан станцын КВТС-10/150 зуух барих ажил, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Элит хорооллын гадна дулаан, цэвэр,бохир усны шугамын ажлыг гүйцэтгэн улсын болон техникийн комисст амжилттай хүлээлгэн өгсөн

Гүйцэтгэсэн БУА-ыг дурдвал:

- УБ хотын гэр хорооллын ЦДАШ -621,0 сая төгрөг-ашиглалтад өгсөн.
- Налайх дүүргийн Дулааны цахилгаан станцын КВТС-10/150 зуух барих -2380.36 сая төгрөг-одоо үргэлжилж байна.
- Зүүнбаян сумын халаалтын зуух шинэчлэлтийн ажил-1284.5 сая төгрөг-улсын комисст хүлээлгэн өгсөн.
- Дэнжийн 1000 орчмыг төвлөрсөн дулаан хангамжид холбох 1, 2-р ээлжийн ажил-350,5 сая-ажил дууссан.
- Говь-Алтай аймгийн Алтай хотын усан хангамж, ариутгах татуургын системийг сайжруулах ажил-791,0 сая төгрөг-ажил дууссан.
- Говьсүмбэр-Хонхорын цэвэр усны шугамын БУА- 130.9 сая төгрөг ажил дууссан.
- Гэр хорооллын айл өрхөд усан халаалттай зуух нийлүүлэх ажил-3466.36 сая төгрөгийн нийлүүлэлт 2013 онд хийгдэж суурилуулж дууссан.
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Элит хорооллын гадна дулаан, цэвэр, бохир усны шугамын ажил-948,0 сая төгрөг
- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхөд 6218 ширхэг усан халаалтын зуух суурилуулах ажлын дуусгалын 715 сая төгрөгийн ажлыг тус тус гүйцэтгэлээ.

Дээрх ажлын үзүүлэлтээс харахад 2014 оны бизнес төлөвлөгөөний биелэлт 1.7 тэрбум төгрөгөөр, ашгийн төлөвлөгөө 36%-аар буюу 44.9 сая төгрөгөөр давж биелжээ.

2014 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байснаар гэр хорооллын айл өрхөд усан халаалтын 20000 ширхэг канад зуух нийлүүлэх гэрээг 2012 онд байгуулсан байсан.

2012 онд зуух нийлүүлэх гэрээ байгуулах үед 1 доллар 1314.65 төгрөгийн ханштай байсан бөгөөд 3.46 тэрбум төгрөгөөр 6248 ширхэг зуух нийлүүлсэн. Нийлүүлсэн зууханд валютын ханшийн огцом өсөлтөөс шалтгаалж 178,0 сая төгрөгийн алданги хүлээсэн юм. Нийлүүлэлтийн энэ алдагдлыг суурилуулалтын зардлаар / нэг зуух угсрахад 380,0 мянган төгрөг/ нөхөж, ашигтай ажиллах нөхцөл бүрдүүлж ажилласан болно.

Үлдсэн 14000 ширхэг зуухыг нийлүүлэхэд /2013 оны 06-р сард 1 доллар-1722,96 төгрөг/ 1 зууханд 168632,03 төгрөг, нийт /14000x168632,03₮/ 2'360'848'420.0₮ /хоёр тэрбум гурван зуун жаран сая найман зуун дөчин найман мянга дөрвөн зуун хорин төгрөг/ -ийн алдагдал хүлээхээр байсан тул бид захиалагч талд хөрөнгө шийдэх хүсэлт тавьсан.

Захиалагч валютын ханшны өсөлтийн зөрүүг олгохгүй гэснээр зуух нийлүүлэлтийн гэрээг цуцлуулж, нэмж алдагдал хүлээх эрсдэлээс хамгаалж чадлаа.

Бусад гэрээт ажлуудыг цаг хугацаанд нь тодорхой хэмжээний ашигтай гүйцэтгэсэн болно.

Тайлант онд дунджаар **70** хүн ажиллаж **516,4** сая төгрөгийн цалин авч сарын дундаж цалин **737,7** мян.төгрөг болж өмнөх /529,6 мян.төг/ оныхоос **39,3%**-хувиар өсчээ.

Байгууллага, хүмүүсээс авах авлага оны эхэнд **839,5** сая төгрөг байсан бол тайлант хугацаанд **4797,5** сая төгрөгөөр өсч, 4782,8 сая төгрөгөөр буурч, оны эцэст **854,26** сая төгрөг болж авлага **14,71** сая төгрөгөөр өссөн байна.

Мөн байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд **446,5** сая төгрөг байсан бол тайлант хугацаанд 2320,0 сая сая төгрөгөөр өсч, 2217,96 төгрөгөөр буурч, оны эцэст **548,5** сая төгрөг болж өглөг **117,6** сая төгрөгөөр өссөн байна.

Компанийн "**Нарлаг**" зочид буудал 2014 онд нийт **89,5** сая төгрөгийн орлого олж **93,03** сая төгрөгийн зардал гаргаж, 3,5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Цаашид зочид буудлын ашиглалтыг сайжруулж, ашигтай ажиллуулах шаардлагатайг анхааруулж байна.

БУА-ын урьдчилгаа буюу захиалагчийн хөрөнгө оны эхэнд **7** тэрбум **669** сая төгрөг байсан бол оны эцэст **3 тэрбум 657** сая төгрөг болж, **4 тэрбум 11,8** сая төгрөгөөр буурсан байна.

Дээрх 7,6 тэрбум төгрөгийн урьдчилгааны **3,46** тэрбум нь гэр хорооллын усан халаалтын канад зуух нийлүүлэлтийн ажлын санхүүжилт байсан бөгөөд 2014 онд борлуулалт болгосноор барилга угсралтын ажлын урьдчилгаа буурсан байна.

Компанийн үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглалтгүй байсан цехүүдийн байрыг засварлаж, компанийн дэлгүүр, гараж болгосон бөгөөд үйл ажиллагааг нь өргөжүүлж, үр өгөөжтэй ашиглуулах шаардлагатай байна.

Компанийн ашиглалтгүй буюу илүүдэлтэй ажлын байруудыг түрээсээр ажиллуулж, 2014 онд 99,2 сая төгрөгийн түрээсийн орлого оруулсан нь өнгөрсөн оныхоос 24,2 сая төгрөгөөр нэмэгджээ.

Эдийн засгийн хямрал, валютын ханшны өсөлтийг дагаж 2014 онд бараа материалын үнэ хэт ихээр өсөж, бидний болон үйлчлүүлэгч, түрээслэгч нарын ажил үйлчилгээ багасаж, ашиг орлого буурч байгаа нь илт мэдэгдэж байна.

Байр түрээслэгч нараас төлбөрөө төлж чадахгүйд хүрч, байраа буцаах явдал гарах боллоо. Одоо контор, үйлчилгээний байранд хэд хэдэн ажлын байр сул байна.

Улсын хөрөнгө оруулалттай барилгуудын БУА-ын санхүүжилт он дамжин олгогдохгүй хүндрэл учруулж байна.

Өнгөрсөн онд ажлыг нь бүрэн хийж, ашиглалтад өгсөн хэд хэдэн томоохон барилгын санхүүжилтын **3,6** тэрбум төгрөг одоо хүртэл олгогдоогүй, хэдийд олгох нь тодорхойгүй байна.

Түүгээр ч зогсохгүй улсын хөрөнгө оруулалттай барилгуудын санхүүжилтыг он дамжуулан тавих, түүнийгээ цааш нь дур мэдэн сунгах явдал хэвших шинжтэй боллоо. Түүний захиалагч төрийн яамд ямар ч хариуцлага хүлээдэггүй системд шилжлээ.

Энэ талаар барилгын байгууллагууд нэгдэж үзэл бодол, учирч байгаа хохирол бусад нөлөөллөө тодорхойлж, асуудлыг шийдвэрлүүлж ажиллахаар тохиролцож байна.

Компанийн 2011-2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд татварын

сая төгрөгийн НӨАТ-ын нөхөн төлөлт, 27.07 сая төгрөгийн торгууль, 32.44 сая төгрөгийн алданги, 25.96 мянган төгрөгийн хүү, бүгд 145.53 сая төгрөгийн акт тавигдсан.Эндээс компани 59,76 сая төгрөгийн цэвэр алдагдал хүлээж байгаа юм. Алдагдал хүлээх болсон нь компанийн санхүүгийн үйл ажиллагаа, хүмүүсийн хариуцлага, ажилд хандах хандлагатай холбоотой.2011-2013 онуудад ажиллаж байсан санхүүгийн ажилтнууд тодорхой шалтгааны улмаас ажлаасаа өөрчлөгдсөн байна.

Цаашид ийм асуудал гаргахгүй байхыг одоогийн ажилтнууд анхаарч ажиллах шаардлагатай болж байна.

2014 онд компанийн улирал жилийн тайлан балансыг хугацаанд нь гаргаж Аудитын байгууллагаар хяналт хийлгэж, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Дүүргийн татвар, Санхүүгийн хэлтэст тушааж ажилласан байна.

Компанийн үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлт, 2014 оны бизнес төлөвлөгөөний биелэлт, ТУЗ-ийн үйл ажиллагаа тогтворжсон зэргээс харахад компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хэвийн явагдаж, үүргээ биелүүлж ажилласан гэж үзэж байна.

2015 онд компанийн зорилтот үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэ оны ажлын ерөнхий чиглэл, зорилго дараах байдалтай байна. Үүнд:

2015 онд компани нийт **4.17** тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх ба үүнээс **4.0** тэрбум.төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэнэ.

2015 онд:

- Говь<sup>1</sup>Алтай аймгийн Алтай хотын цэвэр усны шугамын төслийн 3-р ээлж-809,0 сая төгрөг
- Гэр хорооллын айл өрхөд усан халаалтын зуух суурилуулах -650,0 сая,
- Дулааны станцын КВТС-150/10 зуух барих ажлын 220,0 сая төгрөг,
- Гэр хорооллын айл өрхийн ЦДАШ-ын ажил-182,0 сая төгрөг
- Дэнжийн 1000 орчмын гадна дулаан хангамжийн ажлын дуусгал -728,0 сая төгрөг
- Зүүнбаян халаалтын зуухны шинэчлэлт- 600,0 сая төгрөг
- Баруун-Урт сумын Элит хорооллын гадна дулаан-803 сая төгрөг.
- Орбитын цэвэр усны шугамын дуусгал-300,0 сая төгрөг

Энэ онд дээрх **4.0** тэрбум төгрөгийн барилга угсралтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгөх үүрэг хариуцлага оногдож байна.

Бизнес төлөвлөгөөгөөр **4.17** тэрбум төгрөгийн борлуулалт, **319.7** сая төгрөгийн цэвэр ашигтай байхаар төлөвлөсөн.

2015 онд барилга угсралтын ажлаа гүйцэтгэхээс гадна компанийн гадаад харилцааг хөгжүүлэх, гадаадын түнштэй хамтарсан сантехникийн материалын худалдаа эрхлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, орон сууц барих ажлыг эхлүүлэх, цаашид үргэлжлүүлэх бодлого боловсруулж ажиллана.

Компанийн бетон эдлэлийн болон төмөр хийцийн цехийг бие даасан үйлдвэр ХХ Компани болгох ажлыг амжилттай зохион байгуулсан.

Одоо төмөр хийцийн болон бетон эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бие даасан ажиллагааг хэрэгжүүлэх, ашгийг нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Баянзүрх дүүргийн 30 машины гаражийн барилгын суурин дээр цэцэрлэг бүхий 15 давхар 98 айлын орон сууц барих зураг төслийг бэлэн болгож, барилга угсралтын ажлыг эхлүүлэх, хөрөнгө зарцуулахыг энэ хурлаар шийдвэрлүүлэхээр асуудал оруулж байна.

Мөн шинээр барих энэ орон сууцны барилгын суурийн талбайд орж байгаа 30 машины гаражийн 1524,4 мянган төгрөгийн өртөг бүхий барилгыг ашиглалтаас хасах асуудлыг хамтад нь шийдвэрлэх санал оруулж байна.

Компани нийт 5800м<sup>2</sup> талбай бүхий 1 давхартаа цэцэрлэгтэй 15 давхар 98 айлын орон сууц барьж, 2016 онд ашиглалтад оруулна. Орон сууц барихад 6450,0 сая төгрөгийн хөрөнгө шаардлагатай байгаа.

Шинээр барих орон сууцны барилгын танилцуулгатай танилцаад саналаа өгөхийг хүсч байна.

Улсын хэмжээнд 2014 онд инфляцийн түвшин 13 хувьд хүрснийг харгалзан 2015 оны удирдлагын зардлыг **249,5** сая төгрөг байхаар төлөвлөж байна.

Компани 2013 онд **3,303** тэрбум төгрөгийн БУА гүйцэтгэж **342.3** сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2014 онд **7 тэрбум 6** сая төгрөгийн БУА, үйлчилгээ гүйцэтгэж **368.5** сая.төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2014 онд БУА-ын борлуулалт өмнөх оныхоос **2.1** дахин өсч, цэвэр ашгийн хэмжээ **33,5 сая** төгрөгөөр буюу 8 хувиар өслөө.

Энэ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж, төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлснийг харуулж байна.

Ажлын үр дүн, компанийн 2014 оны үйл ажиллагаа, болон санхүүгийн тайланд **хангалттай** гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мөн 2015 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, орон сууц барих асуудлыг батлуулахаар хуралд хэлэлцүүлж байгаад санал бодлоо илэрхийлж баталж өгөхийг хүсье.

Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилт хүсэн ерөөе.

Хүрд ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл  
2015.04.10